



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/634

Арвайхээр

Аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Бүтээлч-Өвөрхангай-2020” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Архидалтгүй-Өвөрхангай” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд архины хамааралтай болон архинд донтох эмгэгтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий аймгийн “Мэргэжлийн баг”, сумдын “Аддиктологийн баг”-ийн үйл ажиллагааг таниулах, сурталчлах, архины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээ, санаачилага, сайн туршлагыг төрийн албан хаагч, иргэдэд түгээн дэлгэрүүлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Яг одоо татгалзъя” уриатай нэгдсэн аяныг 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд зохион байгуулж буй “Яг одоо татгалзъя” аяныг төрийн болон төрийн бус байгуулага, аж ахуйн нэгж байгууллагуудад үр дүнтэй зохион байгуулж, аян зохион байгуулахтай холбоотой заавар, зөвлөмжийг өгч ажиллахыг аймгийн “Мэргэжлийн баг”-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн арга хэмжээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд 2020 оны 01 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг), аймгийн Мэргэжлийн баг (М.Золзаяа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101181